GC COACH

# Хэрэглэгчийн гарын авлага

MT5-д зориулсан арилжааны дасгалжуулагч индикатор

Хувилбар 1.10 · Үнэгүй хэрэгсэл

**Зохиогч:**
**Gold Compass Pro**

# Агуулга

1. GC Coach гэж юу вэ? ..... 3
2. Суулгах ..... 3
3. Тохиргоо ..... 3
4. Самбарын тайлбар ..... 4
   Хэсгүүд ..... 5
   Өнгөний утга ..... 5
5. Зөвлөгөөний төрлүүд ..... 5
6. HTML тайлан ..... 6
7. Статистикийг хэрхэн тооцдог вэ? ..... 7
8. Түгээмэл асуулт ..... 8
9. Анхааруулга ..... 8

# 1. GC Coach гэж юу вэ?

GC Coach нь таны MT5 дансны арилжааны түүхийг уншиж, хэзээ, юугаар ашиг олж, юугаар алдаж байгааг статистикаар гаргаж, график дээр дасгалжуулагч шиг зөвлөгөө өгдөг үнэгүй индикатор юм. Индикатор өөрөө арилжаа хийхгүй, зөвхөн мэдээлэл харуулна.

GC Coach дараах зүйлсийг хийнэ:

- Одоогийн цагт таны түүхэн үр дүнг харуулж, алдагдалтай цагт анхааруулна.
- BUY, SELL алин дээр илүү сайн болохыг харуулна.
- Ашигтай болон алдагдалтай позицоо хэдэн минут барьдгийг харьцуулна.
- SL-гүй арилжаа, алдсаны дараах яаруу арилжаа, том лот, хэт олон арилжааг илрүүлнэ.
- Өнөөдрийн үр дүн, дараалсан алдагдлыг хянаж, завсарлага авахыг сануулна.
- Нээлттэй позиц бүрт тохирсон зөвлөгөө өгнө.
- Нэг товчоор Монгол хэл дээрх HTML тайлан гаргана.

# 2. Суулгах

1. MT5 дээр «Файл» → «Өгөгдлийн хавтсыг нээх» (File → Open Data Folder) дарна.
2. Нээгдсэн хавтсын MQL5 → Indicators хавтсанд GC_Coach.mq5 файлыг хуулна.
3. MetaEditor-оор файлыг нээж, «Compile» (F7) дарна. Алдаа гараагүй эсэхийг шалгана.
4. MT5-ын «Navigator» цонхны «Indicators» хэсгээс GC Coach-ийг шинжлэх символын график руу чирнэ.
5. Тохиргоог шалгаад «OK» дарна. Самбар графикийн баруун дээд буланд гарна.

**Анхаар:** DLL болон автомат арилжааны зөвшөөрөл шаардлагагүй. Индикатор зөвхөн таны дансны түүхийг уншина.

# 3. Тохиргоо

Ихэнх тохиргоог анхны утгаар нь ашиглахад болно. Хамгийн чухал нь «Таны цагийн бүс» ба «Magic шүүлтүүр» юм.

| Тохиргоо | Анхны утга | Тайлбар |
|---|---|---|
| Бүх символыг хамруулах | false | false бол зөвхөн энэ графикийн символ. true бол дансны бүх символ. |
| Magic шүүлтүүр | -1 | -1 бол бүх арилжаа, 0 бол гараар хийсэн арилжаа, бусад тоо бол тухайн EA-ийн арилжаа. |
| Хэдэн хоногийн түүх ашиглах | 90 | Статистик гаргахад ашиглах хоногийн тоо. |
| Таны цагийн бүс | 8 | Улаанбаатар = 8. Самбар ба тайлангийн бүх цагийг энэ бүсээр харуулна. |
| Дүгнэлт гаргах доод позицийн тоо | 5 | Үүнээс цөөн позицтой ангилалд дүгнэлт гаргахгүй («Мэдээлэл хангалтгүй» гэж гарна). |
| «Алдсаны дараа» гэж үзэх хугацаа | 30 | Алдагдалтай позиц хаагдсанаас хойш хэдэн минутын дотор нээсэн арилжааг «алдсаны дараах» гэж үзэх вэ. |
| Өдөрт хэт олон арилжаа | 10 | Үүнээс олон арилжаа хийсэн өдрийг «хэт олон» гэж үзнэ. |

| Тохиргоо | Анхны утга | Тайлбар |
|---|---|---|
| Самбарыг баруун талд | true | false бол зүүн талд байрлана. |
| Хэвтээ / Босоо зай | 10 / 30 | Самбарын байрлал (пиксел). |
| Үсгийн хэмжээ | 9 | Самбарын үсгийн хэмжээ. |
| Нэг мөрийн дээд тэмдэгт | 60 | Урт мөрийг хэдэн тэмдэгтээр таслах вэ. |
| Нээлттэй позицын зөвлөгөө | true | Нээлттэй позиц бүрт зөвлөгөө харуулах эсэх. |
| Товч харагдац | false | true бол зөвхөн «Одоо», «Өнөөдөр», «Нээлттэй позиц» хэсгийг харуулна. |

## 4. Самбарын тайлбар

Самбар дээрээс доош «Нийт дүн → Одоо → Өнөөдөр → Нээлттэй позиц» дарааллаар харагдана. Зүйл бүр өнгөт цэг ба цагаан гарчигтай, доор нь жагсаалт, хамгийн доор нь «→» тэмдэгтэй зөвлөгөө байна.




*Зураг 1. GC Coach самбар (жишээ өгөгдөл)*

### Хэсгүүд

| Хэсэг | Агуулга |
|---|---|
| Нийт дүн | Сүүлийн N хоногийн цэвэр ашиг/алдагдал, ялалтын хувь, profit factor, хамгийн их уналт. |
| Одоо | Одоогийн цаг (УБ), өнөөдрийн гараг, BUY ба SELL, барьсан хугацаа зэрэг түүхээс гарсан дүгнэлт. |
| Өнөөдөр | Өнөөдрийн позицийн тоо, нийт дүн, дараалсан алдагдал, хэрэгтэй бол завсарлага авах санамж. |
| Нээлттэй позиц | Нээлттэй позиц бүрийн хугацаа, ашиг/алдагдал, SL байгаа эсэх, юу хийх зөвлөгөө (хамгийн ихдээ 4). |

### Өнгөний утга

| Өнгө | Утга |
|---|---|
| ● Улаан | Анхаар: алдагдалтай цаг, SL-гүй позиц, дараалсан алдагдал гэх мэт. |
| ● Ногоон | Сайн: ашигтай цаг, ашигтай позиц. |
| ● Цэнхэр | Мэдээлэл. |
| ● Алт | Болгоомжил: шууд аюул биш ч анхаарах зүйл. |
| Саарал | Мэдээлэл хангалтгүй. |
| → Алт / Улаан | Юу хийх вэ гэсэн зөвлөгөө. |

## 5. Зөвлөгөөний төрлүүд

Зөвлөгөө бүр зөвхөн хангалттай позиц (анхны утгаар 5-аас дээш) байгаа үед гарна.


| Зөвлөгөө | Хэзээ гарах вэ | Юу хийх вэ |
|---|---|---|
| Муу цаг | Одоогийн цагт нээсэн арилжааны нийт дүн сөрөг, ялалт нь таны дунджаас бага. | Хүлээж харах, эсвэл лотоо хагасалж багасгах. |
| Сайн цаг | Одоогийн цагийн дундаж ашиг таны нийт дунджаас их. | Ердийнхөөрөө арилжаа хийх. |
| Муу гараг | Өнөөдрийн гарагт нээсэн арилжааны нийт дүн сөрөг. | Илүү болгоомжтой арилжаа хийх. |
| BUY ба SELL | Нэг чиглэл ашигтай, нөгөө нь алдагдалтай. | Алдагдалтай чиглэлдээ болгоомжтой байх. |
| Барьсан хугацаа | Алдагдалтай позиц ашигтайгаасаа 1.5 дахин удаан барьдаг, эсвэл ашгаа хэт эрт хаадаг. | Эрт хаах дүрэм тогтоох, эсвэл ашгаа удаан барих. |
| Дундаж алдагдал том | Дундаж алдагдал дундаж ашгаас том. | Ялалтын хувийн доод хязгаарыг мэдэх. |
| SL-гүй позиц | SL тавиагүй позиц 5-аас олон. | Заавал SL тавих. |
| Алдсаны дараах арилжаа | Алдсанаас хойш 30 минутын дотор нээсэн арилжаа бусдаасаа муу. | Алдсаны дараа завсарлага авах. |
| Том лот | Ердийнхөөс том лотоор хийсэн арилжаа алдагдалтай. | Лотоо тогтмол байлгах. |
| Хэт олон арилжаа | Өдөрт 10-аас олон арилжаа хийсэн өдрүүд бусад өдрөөс муу. | Өдрийн арилжааны тоогоо хязгаарлах. |

| Зөвлөгөө | Хэзээ гарах вэ | Юу хийх вэ |
|---|---|---|
| Өнөөдөр | 3 удаа дараалан алдсан, эсвэл өнөөдрийн алдагдал ердийнхөөс 2 дахин их. | Завсарлага авах, өнөөдөр зогсох. |
| Нээлттэй позиц | SL алга; ашигтай боловч дундаж хугацаанд хүрээгүй; дундаж алдагдлаас хэтэрсэн гэх мэт. | Самбарын «⟶» зөвлөгөөг дагах. |

## 6. HTML тайлан

Самбарын доорх «Тайлан гаргах (HTML)» товчийг дарахад тайлан хадгалагдана.

1. «Тайлан гаргах (HTML)» товчийг дарна.
2. Тайлан MQL5\Files\GC_Coach хавтсанд report_XAUUSD_20261109_1200.html гэх мэт нэрээр хадгалагдана. Хадгалсан замыг самбарын доод хэсэг болон «Experts» цонхноос харж болно.
3. Файлыг хөтөч (Chrome, Edge гэх мэт) дээр нээнэ.




*Зураг 2. HTML тайлангийн дээд хэсэг (жишээ өгөгдөл)*




*Зураг 3. HTML тайлангийн доод хэсэг (жишээ өгөгдөл)*

| Хэсэг | Агуулга |
|---|---|
| Гол үзүүлэлтүүд | Цэвэр P/L, ялалтын хувь, profit factor, дундаж ашиг/алдагдал, хамгийн их уналт, дараалсан ашиг/алдагдал. |
| Ашгийн муруй | Позиц бүр хаагдсаны дараах нийт P/L. Алтан цэг = хамгийн өндөр, улаан цэг = хамгийн нам. |
| Өдөр тутмын P/L | Сүүлийн 45 өдрийн өдөр бүрийн дүн. |
| Цагаар (УБ) | Аль цагт нээсэн арилжаа ашигтай, алдагдалтай вэ. |
| Гарагаар | Долоо хоногийн гараг бүрийн дүн. |
| Барьсан хугацаагаар | Хэдэн минут барихад ашигтай вэ. |
| Ялалт / ялагдал | Ялалтын хувь ба BUY, SELL-ийн дүн. |
| Гол дүгнэлт | Самбартай ижил зөвлөгөө. |
| Дэлгэрэнгүй | BUY/SELL, SL-тэй/SL-гүй, лотын хэмжээ, алдсаны дараах арилжааны хүснэгт. |

## 7. Статистикийг хэрхэн тооцдог вэ?

- Позиц бүрийн нээлт ба хаалтын арилжааг (deal) нэгтгэж, ашиг + своп + шимтгэлийг нийт дүн гэж тооцно.
- Цагийн статистикийг позиц нээсэн цагаар, өдрийн статистикийг позиц хаасан огноогоор (таны цагийн бүсээр) тооцно.
- Нээх үедээ SL-тэй байсан, эсвэл SL-ээр хаагдсан позицыг «SL-тэй» гэж үзнэ.
- «Ердийн лот» гэдэг нь таны бүх позицын лотын дундаж утга (медиан) юм.

- Хэсэгчлэн хаагдсан ч нээлттэй хэвээр байгаа позицыг статистикт оруулахгүй.
- Түүхийг 30 секунд тутам, самбарыг 5 секунд тутам шинэчилнэ.

## 8. Түгээмэл асуулт

**«Мэдээлэл хангалтгүй» гэж гарна.** Түүх богино эсвэл позиц цөөн байна. «Хэдэн хоногийн түүх»-ийг нэмэх, эсвэл «Дүгнэлт гаргах доод позицийн тоо»-г багасгана.

**Цаг буруу харагдана.** «Таны цагийн бүс»-ийг шалгана. Улаанбаатар бол 8.

**Самбар дэлгэцнээс хэтэрнэ.** «Товч харагдац»-ыг true болгох, эсвэл «Үсгийн хэмжээ»-г багасгана.

**EA-ийн арилжааг тусад нь харахыг хүсэж байна.** «Magic шүүлтүүр»-т тухайн EA-ийн magic дугаарыг оруулна. Гараар хийсэн арилжааг харах бол 0.

**Тайлан хадгалагдахгүй байна.** «Experts» цонхны мессежийг шалгана. MT5-ын өгөгдлийн хавтсанд бичих эрх байгаа эсэхийг шалгана.

## 9. Анхааруулга

GC Coach-ийн бүх дүгнэлт таны өнгөрсөн арилжааны түүхэн статистик юм. Энэ нь ирээдүйн үр дүнг баталгаажуулахгүй. Арилжаа хийх эсэх, лотын хэмжээ, эрсдэлийн шийдвэрийг та өөрөө гаргана. Арилжаа эрсдэлтэй.

Бидны хийсэн дараах бүтээгдэхүүнийг сонирхоорой.

1. Зөвхөн алтны арилжаанд  зориулсан бүрэн автомат робот

https://www.mql5.com/en/market/product/204159

2. Smart Money concept (ICT)-ийн FVG болон бусад арилжааны стратегит суурилсан индикатар.

https://www.mql5.com/en/market/product/203099